

XX зууны эхэн үеийн монголчуудаас түүхэндээ хандаж ирсэн байдал

1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Монголчууд Манж гүрнээс салж, бие даан тусгаар тогтносноо дэлхий дахинд албан ёсоор зарлаж, Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжилсөн билээ.

1911 онд Монголчууд Манж Чин гүрнээс салж, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан явдал бол монголчуудын түүхэнд шинэ эрин үеийг нээсэн юм. VIII Богд Жавзандамба хутагтыг хаанд өргөмжилсөн нь Монгол туурга тусгаар улс болсоны шинж тэмдэг болсон төдийгүй олон монголчуудын итгэл бишрэлийн илэрхийлэл болсон юм. Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хааны сэнтийд өргөмжлөөд, улсын цолыг Монгол, оны нэрийг Олнаа өргөгдсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрийдэж, XX зууны эхээр Ази тивд Монгол улс сэргэн мандсаны шинэ түүх эхэлжээ.¹

Энэ үед монголчууд, тухайлбал төр улсаа сэргээн байгуулахдаа, байгуулсан төрийн зүгээс өөрийн үндэсний түүх, уламжлалаа хэрхэн мэдэж ойлгож ирсэн хийгээд түүхэндээ хэрхэн хандаж байсан талаар энд товч өгүүлэх юм.

1911 онд үндэсний хувьсгалын үр дүнд Манж гүрний эрхшээлээс гарч, Монголчууд тусгаар тогтнол, төр улсаа сэргээн байгуулсан билээ. Манжид дагаар орсноос хойшхи монголчуудын түүхэнд үндэстэнийг сэрээсэн хамгийн том үйл явдал энэ байлаа.

1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Хүрээний төв ордонд Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжилсөн Төрийн их ёслолын үйл ажиллагаа:

Энэ үйл явдлын талаар уг ёслолын ажиллагаанд оролцогчийн байр сууринаас бичиж үлдээсэн, маш сонирхолтой бүтээл бол Г.Навааннамжил авгайн Өвгөн бичээчийн өгүүлэл² болой. Тэрээр бичихдээ: “Мөнөөхөн өвлийн дунд сарын шинийн есөн болж ирэв. Мөнхүү өглөө чуулганы даргын жасааны түшмэл, бичээч нарын хамт залан Дашдондов, Анваан³ нар малгай, хүрэм болон Их Хүрээний төвийн шар ордны тэнд очиж, мориноос буугаад их хаалганы өмнө хүрэхэд олон хүн хуралдаж, үнэхээр нүд алдам их байв. **Отго жинс хүрэм эрэн дээлтэй ноёд, түшмэд, хутагт хувилгаад, лам нар жагсан хүлээж байна...**

Богд, Цагаан дарын хамт их ёслолоор явж ирэхэд тэдгээр хуралдагсад сөгдөн, нам гүм. Богд хатны хамт, шар өнгөтэй алтан туг бүхий дөрвөн дугуйтай гоё орос тэргэнд сууж, хиа лам найман хүн тэргийг дамнан хөтөлж явна. Өмнө нь донир, сойвон, бараа бологч зэрэг том лам нар жагсан явах ба улаан хуйтай сэлэм зүүсэн хоёр гурван хар ноён зам удирдана. Олон шадар цэрэг замын хоёр талаар буу зэвсэгтэй, ёслолын хувцастай жагсан явна. Богд, хатны хамт шар ордны дунд хаалгаар явж, орд гэртээ ормогц тэдгээр ноёд, лам нар цөмөөр дагалдаж ороод шадар ихээхэн ноёд, лам нар нь бүгд орд гэрт орж очсон байна. Бусад ноёд нь төрийн ордны өмнө зогсож хүлээнэ.. Ордны гадаад үүд,

¹ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, нэмж баяжуулсан хоёр дахь хэвлэл, УБ., 2011 он.

² Г.Навааннамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар

³ Г.Навааннамжил гуай өөрийгөө ийнхүү нэрлэсэн буй.

улаан шөргийн дотор ба гадна мөн сайныг цэнгэлдэхэд дуртай хэмээх алтан үсгийн илэрхийлэл бүхий ногоон ваартай юаньпайн хойд талаар үй олон энгийн лам, хар ард цугларан үймэх нь үнэхээр шинэ нээсэн шоргоолжийн үүр мэт”⁴ хэмээжээ.

Тэрбээр цааш өгүүлрүүн: “Үдийн үе болоход ордны зүүн тасалгаанд бий Богдын тугдам гэдэг гэрийн үүднээс эхлэн **төрийн ордны хоймор байгаа дөрвөн арсланы дүрсийг сийлж түшүүлсэн элдэв алтан хээт хааны ёслолын өндөр тавцан бүхий олон давхар магнаг олбог түшлэг хүртэл ба мөн Очирдара гэдэг гэр дуганд замнаж оруулах, хүн явж багтах нарийхан банзан шалтай, шар торго дэвссэн зам “гардан”-ыг бэлтгэв.**

Богд, эх дагина хоёр хар үнэг гэдэг үнэт үстэй малгайд очир жинс хадаж, эрээн дээл, булган цоохор хүрэм өмсөж, явганаар шадар ноёд, сойвон, донир нарыг дагалдуулан хойноо шар торгон ба алтан саа луу хээт шүхэр хоёр тогосны өдөн шүхэр нэг, ийм гурван шүхрийг бариулж, өмнө нь донир ба улаан хуйт сэлэм зүүсэн хар ноён хоёр хүн удирдан, мөнөөхөн бэлтгэсэн шар торгон зам дээгүүр алгуурхнаар алхуулан явахад нь шадар ноёд дөрвөн хүн Богд, эх дагинын хоёр талаас нь түшиж хүндэтгэн явна. Богд, эх дагинын хамт Очирдара гэдэг дуганд ороод хойш явж төрийн ордонд орж очив. Төрийн ордонд бараалхан орох эрх бүхий ихээхэн хутагт хувилгаад, хан, ван, бээл бээс гүн засаг тайж нар цөм дагалдан орцгоов.

...төрийн ордноос хуучин хүрээний монгол сайд байсан бэйс Пунцагцэрэн гартаа нэлээд том бичиг барьж ирээд хишиг тараах зарлиг буув гэж өндөр дуугаар хэлнэ. Бээс Пунцагцэрэн тэрхүү хишиг тараах зарлигийг уншиж л байв. Үг нь ер тодорхой сонсдохгүй, чинээгээрээ чих тавьж сонсвол: Богдыг **Монгол Улсын** наран гэрэлт түмэн наст Богд эзэн, Цагаан дарыг улсын эх гэж өргөмжилж, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрийдэж, Их Хүрээг улсын төв Нийслэл Хүрээ болгон **Монгол улсыг** байгуулж, дэлгэр их ёслолыг явуулав⁵ хэмээжээ.

Богд хааны монгол бичгийн багш Хурц Магсаржав бичихдээ: “Монголын төрийн орд, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх таван яамны байгуулалтыг урьдаар засацгаан бэлтгэхэд төв гэрүүдийг цөм **монгол гэр** үйлдэн байгуулаад Монголын цагаагчин гахай жилийн 11 дүгээр сарын шинийн 9 бөгөөд Европын 1911 оны 12 дугаар сарын 16 (29–О.Б)-ны өдөр Богд Жавзандамба хутагт ламыг Монгол Улсын хаанд өргөмжлөх явдлыг гуйн айлтгаж мөн өдрийн 11 цагт эрдэнийн ширээнд залж суулгаад басхүү шавь охин эрдэнэ сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд өргөмжлөн хамтаар ёслох учир **хааны эрдэнэ, хасын тамга, алтан үсэгт өргөмжлөл ба Монголын газраас гарсан ёсны юм есөн цагаан билгийн⁶ цагаан тэмээ, мөнгөн буйл, булган мулцагт нижгээд цагаан морь, булган мулцагт наймаад хадаг сэлтийг бэлэглэн өргөхдөө төрийн ордоноо хуралдсан хүн бүгдээр хичээнгүйлэн Богд хаан, Улсын эхэд тус тус гурвантаа сөгдөж, есөнтөө толгой дохиж”⁷ мөргөсөн хэмээжээ.**

Эзэн Чингисийг Их Монгол Улсын эзэн хаанаар өргөмжилөхөд Монгол гэр –төрийн ордон байсан нь эргэлзээгүй хэрэг байх, Плано Карпинигийн бичснээр бол зааны ясаар хийж, алт болон эрдэнэсээр чимсэн хаан суудал байсан тухай тэмдэглэсэн буй.

“Монгол Улсын автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг”

⁴ Г.Навааннамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар

⁵ Г.Навааннамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар, 182-185 дахь тал

⁶ Нэгэн цагаан есөн цагаан билгийн үнэ 280 лантай тэнцэж байжээ.- УТА. Ф.А3, д.1, х.н.369, х.5

⁷ Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., 1994, 12 дахь тал

энэ талаар өгүүлэхдээ “Халхын таван аймгийн хаад, чуулганы дарга, жанжин, олон засаг ноёд, хутагт хувилгаад, шанзодва, да лам нар язгууртан тушаалтан тайж түшмэд бүрнээ Их Хүрээнд хуралдан хүрч ирээд, бүгдээр нийлж зөвлөлдөн хэлэлцэж, Европын нэгэн мянга есөн зуун арван нэгдүгээр он, Дайчин гэдэг Манж улсын Хэвт ёсны гуравдугаар он, Монголын арван тавдугаар Рабжунгийн цагаагчин гахай жилийн өвлийн дундад сарын шинийн есний өдөр, **Монгол Улсын тулгур төрийг** нээн, тусгай улс байгуулж, бүхний багш Богд Жавзандамба ламтныг Улсын эзэн хаанд өргөмжлөн, **Эрдэнийн их сууринд** суулгаж, шашин төрийн бүрэн эрхийг хослон бариулж, улсын нэрийг Монгол, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрийдэж, Их Хүрээг улсын төв нийслэл болгон, дотоод, гадаад, цэрэг, сан, шүүх таван яамыг байгуулж, засгийн хэргийг хуваан шийтгүүлэв”⁸ хэмээжээ.

Манжич Л.Дэндэв авгай энэ талаар өгүүлэхдээ: “мөнхүү түр засгийн газраас **Монгол** өөртөө тогтнох улс болж, Богдыг Монгол Улсын хаанд өргөмжлөн **эрдэнийн сууринаа** суулгах өдөр цагийг тогтоож, Хүрээн дэх Оросын ерөнхий консулд албанаар мэдэгджээ”⁹ хэмээн тэмдэглэжээ.

Х.Пэрлээгийн тэмдэглэж авсан дурсамжид “Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч наран гэрэлт хаан” өргөмжлөх тунхаг бичгийг Халхын Сайн ноён хан **Намнансүрэн** баруун өвдөг дээрээ сөгдөн сонсоход төрийн ёслолд оролцогсод цөм баруун өвдөг дээрээ сөгдөн мөргөсөн байна. Тулгар төр байгуулсан хэрэгт онц хүчин зүтгэгсэд ба нийтэд хишиг тараах зарлигийг **Да лам Цэрэнчимэд** уншсан хэмээн бичжээ¹⁰. Мөн Богдод хундага өргөхөд Чин ван Ханддорж, гүн Намсрай, тамга өргөхөд да гүн Чагдаржав, өргөмжлөлд Сайн ноён Намнансүрэн, Бурханд хамба номун хан Пунцаг, дэд хамба Содномдаржаа, ном дор Манзушир хутагт Цэрэндорж, Жалханз хутагт Дамдинбазар, суварганд ноён номун хан Жигмэддорж, Эрдэнэ хамба Лувсанцэрэндагвадогми, долоон эрдэнийг Шанзодба Бадамдорж, мэргэн хамба Дэмбэрэлдаш, Түмэн оны хангагчийг да жүн ван Гомбосүрэн, мэргэн ван Ананд Очир, ерөөл айлтгахад Да лам Цэрэнчимэд нар гүйцэтгэсэн тухай архивын эх сурвалжид тэмдэглэжээ.

Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанд өргөмжилж, зууч түшмэлээс айлтгасан ерөөл “Ува сайн амгалан болтугай. Монголын хан, ван, бэйл бэйс, гүн засаг, хамба, цорж, хутагт хувилгаад, лам нараас дараалан шар, хар олон нийтээр гурван үүдний чин бишрэлээр хичээнгүйлэн мөргөж өчин айлтгах нь: Бидний олон монгол шавь боолчууд цөм эртний ерөөл барилдлагын хүчээр эдүгээ цагийн бэрхэд даншилгүй гайхамшигт Очирдара Богд лам хийгээд Эх дагина юугаа ойр дагалдан тойрч зүйл зүйлийн жолоодон сургах соёлыг хүлээн хүртэж сүслэн шүтсээр харш дайсны этгээдээс ангижирсан, үүн дор бүгдээр тэсгэлгүй баярлан нэгэн сэтгэлээр зөвлөөд өлзий учрал бүрдсэн энэ сайн өдрийг сонгон тохиолдуулж **манай Монгол улсын эртний их Чингис хааны үрийн үр Түшээт ханы хөвгүүдээс дараалан шинж тэмдэг онц тодорхойгоор хувилж гурван цагийг илэрхийгээр заасаар өчнөөн зуун жилд Олноо өргөгдсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч аврал итгэл хамгийг айлдагч оройн**

⁸ Монгол Улсын автономн хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг УБ., 1992, 9 дэх тал

⁹ Л.Дэндэв Монгол Улсын товч түүх, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, нэрсийн хэлхээ хийсэн С.Чулуун, УБ., 2006, 88 дахь тал

¹⁰ Г.Дашням нар Пэрлээгийн Монголчуудын байгаль хамгаалах, утга соёлын түүхэнд холбогдох хоёр бүтээл, УБ., 2001, 30-31 дэх тал

чандмань эрдэнэ арга билгийг хосолж таалан зохиосон Очирдара гэтэлгэгч Богд гэгээнтнээ Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст Богд хаанд өргөмжлөн” буй хэмээн анх удаа Чингис хааны нэр гарч буй.

Үүний дараа Улсын эзэн хаанаар өргөмжлөгдсөн Богд гэгээнтэн хишиг тараах зарлиг буулгасан билээ. Уг зарлигаар “Тулгур төр байгуулах тухайн хэрэгт онц хүчин зүтгэж явсан” хэмээн Монгол Улсын Засгийн газрын анхны сайдаар өргөмжлөгдсөн **таван хүний дөрөв нь Эзэн Чингисээс улбаатай алтан ургийн хүмүүс байв**. Үүнд: Түшээт хан аймгийн засаг хошой чин ван Ханддорж, Сэцэн хан аймгийн Засаг хошууны бэйс Гомбосүрэн, Түшээт хан аймгийн засаг улсын түшээ гүн Чагдаржав, Мөн аймгийн гүнгийн зэргэ засаг тэргүүн зэргэ тайж Намсрай нар багтсан бөгөөд бусад хишиг хүртэгдсийн дийлэнхийг Эзэн Чингисийн угсааны хан ван гүнгүүд эзэлж байлаа. Тэдгээр дотор Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Засагт хан Содномравдан, Сайн ноён Намнансүрэн нар тэргүүлэн оржээ¹¹.

Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын Хаан ширээнд өргөмжлөхөд түүнд өргөн барьсан зүйлсийн талаар тодруулах нь

Монголчууд эртнээс төрийн аливаа ёслол үйлдэхдээ есөн цагаан их бэлгийг өгдөг уламжлалтай байсан билээ. Энэхүү уламжлалыг 1911 онд энэтхэг түвдийн төрийн бэлгэдлийн зүйлстэй хослуулан хэрэглэсэн ажээ. Эх сурвалжууд Богдыг Хаанд өргөмжлөөд хаан эрдэнэ, есөн цагааны билэг өгсөн хэмээн бичжээ. Өөрөөр хэлбэл Богдыг хаанд өргөмжлөхдөө энэтхэг түвдийн уламжлал, эртний монголын төрийн уламжлалыг хослуулсан байна хэмээн үзэж болохоор байна.

Бидэнд мэдэгдэж байгаагаар, Магсар хурц Богд хаанд “хааны эрдэнэ, хасын тамга, алтан үсэгт өргөмжлөл ба Монголын газраас гарсан ёсны юм есөн цагаан билгийн цагаан тэмээ, мөнгөн буйл, булган мулцагт нижгээд цагаан морь, булган мулцагт наймаад хадаг сэлтийг бэлэглэн”¹² өргөсөн хэмээн тэмдэглэжээ.

Хаан төрийн долоон эрдэнэ

Хаан эрдэнэ буюу хан төрийн долоон эрдэнийн тоонд хүрд, чандмань, хатан, түшмэл, заан, морь, жанжин (*баатар*) ордог ажээ. Эдгээр долоон эрдэнийг Энэтхэгийн оронд Загарвардын хааны эдэлж байсан эрдэнийн зүйл хэмээн тайлбарласан буй.

Тэрхүү долоон эрдэнийн тус бүрийн тайлбарыг сонирхвоос,

1. “Хүрд эрдэнэ” нь алтан эрдэнээр өөрөө бүтсэн ариун номын эгшгийг дуурсган эргэдэг хорол ажээ.

Энэ нь төр улс, айл гэр, хүмүүс номын гэрлээр гийгүүлэгдэн, юунд ч дийлдэшгүй бат байхыг бэлгэдсэн байна. Монгол гэрийн тооно хорол хэлбэрийн дүрстэй байдаг билээ. Харин Богдыг Монгол Улсын хаанд өргөмжлөхдөө энэхүү хүрд эрдэнийг Богд хааны дээлний гадуур өмсдөг хүрэмний урд энгэр хэсэгт дугариг хэлбэрийн хоролыг үйлдэж хадаж өгсөн байна. Энэ бол хааны долооны эрдэнийн нэгийг үйлдсэн хэрэг хэмээн ойлгож болохоор ажээ.

1911 онд Богдыг Улсын эзэн хаанаар өргөмжлөхөд түүний хүрэмний ар, өвөр, баруун, зүүн мөрөнд фүс тэмдэг хадсан байна. Хүрэмний энгэрийн фүс нь алтан хорол өртэй,

¹¹ Үндэсний төв архив Ф.А3, д.1, х.н.2, 16 дахь тал

¹² Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., 1994, 33 дахь тал

эргэн тойрон эрдэнийн дүрсээр (хаан бугуйвч, хатан сүйх, зоосон хээ, заан соёо, загасан нуруу, үнэртэн шүр, уул усны дүрсээр) хүрээлсэн дугариг хэлбэртэй байна.

Арын фүс нь таван тахил буюу дод н-а (*толь, үнэртэн хүж, хөгжим, амьтан, хадаг*) болон гачил бүхий дугариг хүрээнд гуутай соёмботой байна. Соёмбоны дээд талын галын дөл нь хөх, нар нь шар, сар нь улаан, түүний доодох гурвалжин нь хөх, гонзгой дөрвөлжин нь шар, дундах зөрсөн загасын баруун тал нь цагаан, зүүн гар тал нь улаан, түүний доторх хөндлөн нь ногоон, гурвалжин нь цагаан, хажуу босоо шулуун нь хар өнгөтэй хийгдсэн байдаг. Энэ нь эртний Энэтхэгийн шидэт арван үсгийн чуулган болсон Нанжувандан хэмээн хураангуй номноос үүсэлтэй болохыг харуулж¹³ байгаа тухай Д.Цогзолсүрэн өөрийн номондоо бичжээ.

Энэхүү хоролыг хааны хүрэмний энгэрт хадсан нь Богд хааныг эртний Энэтхэгийн Махасамади хааны адил Олноо өргөгдсөн хааны хувилгаан хэмээсний учир Загварди хааны сүлдлэн тахиж байсан хоролыг ийнхүү энгэрийн фүс болгожээ.

Уг хүрэмний ар талд Соёмбыг үйлдэн хадсан байна. Энэ нь Богд хаан бол Анхдугаар Богд өндөр гэгээн Занабазарын хувилгаан хэмээн үзсэний учир тийнхүү Занабазарын зохиосон билэгдлийн ном соёмбоны дүрийг ийнхүү авч хэрэглэжээ. Энэ бол соёмбо монголын төрийн бэлгэдэл болсоны илэрхийлэл юм.

Хааны хүрэмний баруун мөрөнд зэндмэнэ, өлзий, хас зэргээр хөвөөлсөн хүрээнд дугариг алтан наран дэвсгэр дээр соёмбо үсгээр нар хэмээн үгийг санскрит хэлээр сурь-яа гэсэн хоёр үсэг болгон алтан саагаар үйлджээ. Зүүн мөрөнд дээрхтэй ижил дэвсгэр дээр сар хэмээх үгийг санскрит хэлээр соёмбоор чан-дара гэсэн хоёр үсэг болгон алтан саагаар бичжээ.¹⁴

Соёмбо үсэг нь угтаа эртний Энэтхэгийн нагар ланз үсгээс эх авсан арга билэг буюу нар сарыг билэгдсэн дууны хөргө болохыг илэрхийлсэн¹⁵ ажээ.

Энэхүү фүс тэмдэг нь Манжийн үед хэрэглэж байсан таван хумст лууны дүрс бүхий фүсийг халж, тусгаар тогтносон хааны хувьд хэрэглэж буй шинэ тэмдэг болсон байна. Харин фүсэнд эртний энэтхэгийн хийгээд бурханы шашины уламжлалаас илүүтэй тусгагдсаныг анхаарах нь зүй буй за.

2.Чандмань эрдэнэ нь гадаад их далайгаас залж авчирсан гайхамшигт ид шидтэй хүн бүгдийн хүслийг хангадаг норов эрдэнийг хэлдэг ажээ.

Энэ эрдэнэ гурав буюу таван дүрсээс бүтдэг байна. Гурван зууван дугуйг нь чандмань хэмээдэг бол тавыг нь зэндмэнэ, норов хэмээдэг байна. Гурван дүрс нь бие, хэл, сэтгэл гурвын хүслийг хангах, таван дүрс нь тэгш таван хүсэл буюу таван мэдрэхүйн баясгалан (*харах, амтлах, үнэртэх, сонсох, хүртэхийн цэнгэл*)-ийг хангана хэмээсэн утгатай ажээ. Чухамдаа Монголчуудын хүслэн болсон тусгаар тогтнол, эрх чөлөөг өнө үүрд батжин энхжихийг бэлгэдэн Богд хааны төрийн тамгыг чандмань бариултай хийсэн байна.

Монгол Улс тусгаар тогтносон улс болохын нэгэн том илэрхийлэл бол Улсын эзэн хаантай болсон хэрэг бөгөөд иймээс Улсын эзэн хааны бүхий л үйл хөдлөл, зан заншил, өмсгөл тэргүүтэнд ихээхэн ач холбогдол өгч, тодорхой агуулгатай байхаар бэлдсэн нь харагдана.

¹³ Д.Цогзолсүрэн Монгол Улсын ноёд, язгууртны зэрэг дэв- төрийн ямбаны хувцас (1911-1919), УБ., 2003, 22-23 дахь тал

¹⁴ Д.Цогзолсүрэн Монгол Улсын ноёд, язгууртны зэрэг дэв- төрийн ямбаны хувцас (1911-1919), УБ., 2003, 23-24 дэх тал

¹⁵ Д.Цогзолсүрэн Монгол Улсын ноёд, язгууртны зэрэг дэв- төрийн ямбаны хувцас (1911-1919), УБ., 2003, 24 дэх тал

БОГД ХААНЫ ТАМГА

Богд хаанд Шашин төрийг хослон баригч, наран гэрэлт түмэн наст хас эрдэнэ тамга–1, мөнгө тамга–1 байснаас гадна Богд ламын хувьд хэрэглэдэг Ламын алтан тамга–1 байжээ. Эдгээр тамгыг хэрхэн хэрэглэж байх талаар Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт хуульчлан заасан байна. Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн гучдугаар дэвтэрт заахдаа: “Нэгэн зүйл. Шашин төрийг хослон мандуулагч Наран гэрэлт түмэн наст Богд хааны хас эрдэнэ тамга 1, мөнгөн эрдэнэ тамга 1. Үүнийг аливаа тархаах зарлиг, хэлтрүүлэх зарлиг, ухуулах, сургах, өргөмжлөл, жуух шар торгоны бичигт дарж хэрэглэнэ”¹⁶ хэмээсэн бол удаах зүйлд “Жавзандамба ламын алтан тамга”-ны тухай заалт орсон байна. Уг зүйлд “Нэгэн зүйл. Шашныг мандуулагч амьтныг жаргуулагч аврал итгэл, хамгийг айлтгагч оройн чандмань Очирдара Жавзандамба ламын алтан тамга нэгийг цутган өргөж, хичээнгүйлэн болгоомжилж эрхэмлэн хадгалуул. Хаан эзэнд айлтгах бичиг ба лам нарт олгуулах гашог шар торгоны бичигт дарж хэрэглэгтүн”¹⁷ хэмээн заажээ.

Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамбын цагаан хаш тамга, мөнгө тамга, Эх дагинын тамга нь эдүгээ Монгол Улсын Эрдэнсийн санд хадгалагдаж байна.

Шашин төрийг хослон баригч, Наран гэрэлт Богд хааны тамга хэмээх үсэг бүхий 1911 онд Монгол Улсын эзэн хаанаар Богд Жавзандамба хутагтыг өргөмжлөөд хийсэн цагаан хаш тамга, мөн мөнгөн тамга болон Монгол Улсын Эх дагинын тамга нь Монгол Улс тусгаар тогтносон бүрэн эрхт улс хийгээд өөрийн эзэн хаантай болохыг илтгэн харуулсан агуулга, шинж чанартай болно.

Богд хааны мөнгөн тамганы дээд талд болон дөрвөн талд нь “Тэнгэр энх, түвшин дэлхий, төр маш бат, шашин маш тунгалаг” хэмээн монгол үсгээр утга төгөлдөр, агуулга гүн бичсэн нь Монголын төрийг өнө мөнхөд бат оршиж, монголчуудын шүтэж ирсэн шашин нь тунгалаг байхыг бэлгэдснээс гадна дэлхий дахинаараа энх түвшин оршиж байхын ерөөл оршихуйг бэлгэдсэн чанартай болсон хэмээн үзүүштэй. Дээрх үгүүдийг бичихдээ тамганы толгойг эх хэмээн үзвээс эх оршин буй талд “тэнгэр” хэмээн бичиж, тамганы дээд талд “энх” хэмээн бичээд зэндмэнэ бариулны нөгөө талд “түвшин” хэмээн бичиж, тамганы эхний эсрэг талд “дэлхий” хэмээж, тамганы зүүн талд “шашин маш тунгалаг”, баруун талд нь “төр маш бат” хэмээн бичсэн байна. Мөн тамганы дээд талыг уг тамгыг үйлдсэн хугацааг бичихдээ “Цагаагчин гахай жилд бүгдээр өргөмжлөн өргөв” хэмээснээс үзвэл энэхүү тамганы эзэн болох Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын эзэн хаанаар 1911 онд өргөснийг бас ийнхүү илэрхийлсэн байна. Эдгээр бүгд өөр өөрийн агуулгатай бөгөөд 1915 онд Богд хаанд өргөсөн Ламын алтан тамганд эдгээр үгс цөм адил буй билээ.

Энэхүү тамганы бариулд хаан төрийн долоо эрдэний нэг болох зэндмэнэ байх бөгөөд түүгээрээ монголчуудын юу санасан есөн хүсэл биелж, монгол үндэстнээрээ тусгаар тогтнон оршиж, энх тунх аж төрөх хүсэл нь биелэхийг бэлгэдсэн амой.

1911 онд монголчууд Манжаас тусгаар тогтноод төр улсаа сэргээн тунхаглан зарлан тунхагласаны дараа Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хааны эрдэнийн ширээнээ суулгаад, эртний Монголын хаад хас боу-бай хэмээх хаш тамгатай байсаныг дагаж, цагаан хашаар тамга хийж, Богд эзэн хаанаа өргөсөн тухай дээр нэгэнтээ дурьдсан билээ.

¹⁶ Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг, Монголоос кирилл бичигт буулгасан О.Батсайхан, З.Лонжид, Ч.Хажидсүрэн, УБ., 1995, 126 дахь тал

¹⁷ Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг, Монголоос кирилл бичигт буулгасан О.Батсайхан, З.Лонжид, Ч.Хажидсүрэн, УБ., 1995, 126 дахь тал

3.Хүний ёсонд эмэгтэй хүн бол эхнэр төдийгүй эх хүн хүн төрөлхтөний нэгэн бат түшиг, тулгуур хань нь байдаг тул төр улс, айл гэрт үзэсгэлэн төгс, саруул ухаан бүрдсэн эрдэм гүйцсэн, журамт бүсгүй нэн чухал байдаг. Учир иймээс үйлийн муу гэмийг тэвчсэн, үргэлжид амгалангаар цэнгүүлэгч, үнэн ариун хатанг хан төрийн долоон эрдэнийн нэгэн болгосон ажээ.

Эл талаар Хурц Магсаржав бичихдээ: “Монголын цагаагчин гахай жилийн 11 дүгээр сарын шинийн 9 бөгөөд Европын 1911 оны 12 дугаар сарын 16 (29. –О.Б)-ны өдөр Богд Жавзандамба хутагт ламыг Монгол Улсын хаанд өргөмжлөх явдлыг гуйн айлтгаж мөн өдрийн 11 цагт эрдэнийн ширээнд залж суулгаад басхүү шавь охин эрдэн сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд”¹⁸ өргөмжилсэн хэмээжээ. Ийнхүү Эх дагина Дондогдулам нь хан төрийн долоон эрдэнийн нэгний шинжийг агуулсан байна.

1911 оны 12 дугаар сарын 29-нд Монгол улсын тусгаар тогтнолоо сэргээн мандуулаад Богдын хатан Дондогдуламыг Эх дагина хэмээн өргөмжлөн, улмаар “шашин төрийг хослон өрнүүлэгч Эх дагины тамга” гэсэн бичигтэй тамга барьж байжээ. Герман улсаас Хятадын Бээжинд сууж байсан Элчингийн газарт дэд консулаар 1920 иод оны үед ажиллаж байсан Херман Гиппэрич 1922 оны 7 дугаар сарын 1-нээс 8 дугаар сарын 8-ны хооронд Монголд ажиллаж байхдаа Богд хаан болон эх дагина нар лугаа уулзаж байсан байна. Иймээс тэрбээр Эх Дагина Дондогдуламын талаар хожим “Уран ухаантай, арга зальтай, зоригтой энэ эмэгтэй нас барснаас хойш Богд хааны ордны эрч хүч ихээхэн суларсан байна”¹⁹ хэмээн бичснийг Германы монголч эрдэмтэн Ута Шёне өөрийн бүтээлдээ оруулсан байдаг. И.Я.Коростовец “Эх дагина илүү чөлөөтэй, эелдэг зантай байж ярилцах үеэр инээмсэглэн ширээ рүү минь дөхөж ирж байлаа”²⁰ гээд “Эх дагина [маш ухаантай], бас Богд өөрөө хараа муутайн улмаас сул дорой болоод байсан учир хатан нь түүнд үлэмж нөлөөтэй байсан гэдэг” хэмээн тэмдэглэж, Эх дагина 1923 онд нас барснаас хойш Богд хаанд зөвлөгч дутсан²¹ хэмээсэн санааг бичсэн нь Эх дагины талаарх дээрх саналтай агаар нэгэн болжээ. Эх дагина 1923 оны 6 дугаар сарын 27-ны өдөр таалал төгсчээ.

4.Хамаг олон амьтныг эрхшээсэн хатуу цаазаар бусдыг үл айлгагч, хатгалдахын сэтгэлээр хэрэг бүгдийг хазгай буруу шийтгэхийг огоот тэвчсэн, ханилсан нөхөдтэйгөө үргэлжид эв зөийг хичээн зөвшигч, хаа явагч олон бүгдээр хүндлэх харилтгүй зоригт түшмэл эрдэнэ нь хан төрийн долоон эрдэнийн нэгэн ажээ.

**5.Цаст уулын өнгө лүгээ тэмцэлдсэн
Цагаан өнгө нь гялбалзаж тодорсон
Цаана цаанаас харшлагчийг буцаах
Цааш эргэж бусдыг хорлохгүй
Цаг мөчийн дотор замба тивийг эргэн ирэх**

¹⁸ Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., 1994, 11 дэх тал

¹⁹ Ута Шёне ХХ зууны 20 иод оны эхээр Монголд албан хэргээр очсон Герман дипломатч нарын зарим тэмдэглэлээс Монголч эрдэмтний олон улсын 8 дугаар их хурал дээр тавьсан илтгэл 2002, Улаанбаатар

²⁰ Иван Яковлевич Коростовец МОНГОЛД ӨНГӨРҮҮЛСЭН ЕСӨН САР (Монгол дахь Оросын Бүрэн эрхт төлөөлөгчийн өдрийн тэмдэглэл) 1912 оны 8-р сараас 1913 оны 5-р сар Эмхтгэгч Оохнойн Батсайхан (Монгол улс), Хянан боловсруулсан: Оохнойн Батсайхан (Монгол улс), Ольга Бакич (Канад улс), Наками Тацуо (Япон улс), УБ., 2010 он

²¹ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О.Батсайхан, Редакторы Базаров Б.В., Ганжуров В.Ц, УБ., 2004, с.166

**Цангах өлсөхийн зүдрэл бүхнийг тэвчсэн
Цогзолсон олон эрдэнийн ачаатай
Цаглашгүй эрдэм төгс заан эрдэнэ төрийн нэгэн эрдэнэ.**

1911 онд Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөөд түүнд зориулан бүтээсэн хан төрийн долоон эрдэнийн нэг нь заан байлаа. Богдыг жаахан байхад нь түүнд зориулж бүтээсэн эсэх, эсвэл дараа нь бүтээсэн алин болохыг тодруулж эс чадсан боловч ямар ч гэсэн түүнд зориулсан “нуруун дээрээ зэндмэнэ эрдэнэ үүрсэн зааны ясаар сийлж хийсэн тоглоомон заан”²² байжээ. Энэхүү тоглоомон заан эдүгээ Богд хааны ордон музейд хадгалагдаж байна.

Богд Жавзандамба хутагт амьтанд дуртай нэгэн байсан бололтой, түүнд лав хоёр ч амьд заан байсан гэдэг.

Хаан төрийн долоон эрдэний нэгийг бодитоор бүтээхээр шийдсэн Богдын таалалаар 1912 оны сүүлч 1913 оны эхээр Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ханддорж тэргүүтэй төлөөлөгчид Орос улсад хийсэн анхны албан ёсны айлчлалын үеэр “бага шиг бор зааныг 22 000 цөлхөөвөр (руб) худалдан авч, 1913 оны хавраас өвлийн дунд сар хүртэл зааныг вагонд ачуулах, хөлөөр нь явуулах зэргээр найман сар гаруй аялуулсаар Хиагт хотноо”²³ авч ирсэн байна. 1924 онд Богд хаан таалал болсоны дараа зааныг харах хүн хомсдож, 1926 оны үед заан нас барсан ажээ.

**6.Тэгш сайхан гоолиг өндөр биетэй тэнхэл чадал, өнгө бялд төгссөн
Тэрэгнээс зөөлөн үлэмж аятай явдлаар
Тэмүүлж татаж алхлан жороолсоор тэр гэхийн завсар ертөнц бүгдийг эргэх Тэнгэр
хүн бүгдийн сэтгэлд зохистой
Тэнцэшгүй эрдэм төгс морин эрдэнэ**

**7.Бадмаараг тэргүүтэй зүйл бүрийн өртөгтэй
Барагдашгүй эрдэнийн санг барьсан
Баясгалангаар амьтан бүгдийг тэтгэсэн
Баялаг өргөн, дорви чимээ бүрдсэн
Баширлаж ихэс олныг хуурахгүй
Бардагнаж доорд амьтныг дарлахгүй
Баатарлаж олон бүгдийг бүрдүүлэхгүй
Балгад мэт орон гэрийг эзлэгч
Бахдам чадал төгс жанжин эрдэнэ**

Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамба хутагтын өмсөж зүүж байсан дээл, хүрэм, титэм зэрэгт тусгаар улсын төрийн тэргүүний шинж, хан төрийн эрдэний шинжүүдийг ямар нэгэн хэмжээгээр оруулахыг хичээсэн нь буй.

Алтан очирт хар үнэгэн титэм, алтан шахуургатай сувдан эрхи, 136 булганы арьсыг зоолж доторлосон луу хээтэй алтан саа бүхий хоргой дээл, 600 гаруй булганы гоцыг зүйж хийсэн эрээн хүрмийг Богд Жавзандамба хутагт Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөгдөхдөө буюу 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр өмсөж байжээ.

Шашин төрийг хослон баригч Наран гэрэлт Богд эзэн хааны зарлиг

²² Үндэсний төв архив Ф.388, д.2, х.н.49, х.82

²³ Үндэсний төв архив Ф.388, д.2, х.н.33, х.84

“Би тэнгэрийн цагийг дагаж төр шашиныг хослон барьж, Монгол улсыг жолоодон тогтоохуй дор үнэнээр тус хийж чадагчдыг хэтэрхийеэ эрхэмлэх бөгөөд эн тэргүүн өргөмжилбөөс зохих Жавзандамба лам болбоос эртний Мин улсын цаг **Их Юань улсын тайцу хааны үе, Халхын Очирбат Түшээт сайн хан Гомбодоржын гэрт хувилгаан гарч**, бурханы шашиныг дэлгэрүүлэн хамаг амьтаныг гийгүүлж, Халхын олон монголчуудыг тэргүүлэн авч, манж монголыг найралдуулан гавьяа байгуулсан учирт умар зүгийн амьтаны итгэл номын Богд хэмээн алтан тамга, алтан навчит өргөмжлөлийн зэрэг зүйл бүрийн ёслолын юм шагнагдаж, Манж эзэн лугаа нэгэн суурин дор суух зэргээр маш өргөмжлөгдсөн анх төрлийн Өндөр Богдоос эхлэн төрөл тутам бэлгэ билэг лүгээ төгөлдөр судар таринийн шашиныг мандуулж, амьтаныг жаргуулсан тус эрдэм зарлигийн ач хязаалш үгүй буй.

Эдүгээ наймдугаар төрлийн Живзандамба лам ч магад гарч дээд бодь сэтгэлийг үүсгэснээс зургаан бармидыг туулгаж, хоёр зэргийн оньсыг боловсруулсан гайхамшигт зохиолыг илтэд болгож, эртний заларсан дээдсийн эши үзүүлсэн ёсоор шар шашиныг хир үгүй дэлгэрүүлж цөвүүн цагийн амьтаны элдэв зүйл зовлон хийгээд гадаад дотоодын цэрэг хямрал буурал бүхний харанхуйг арилгаж, хамаг Монгол овогтоныг сайн дор удирдан төгс зоны ид дэлгэрсэн мэт амгалан жаргалангийн цогийг эдлүүлэн чадсаны тулд үе үеийн хэрэглэсэн олон зүйл янба шашиныг мандуулах амьтаныг жаргуулагч цолын дээр аврал итгэл хамгийг айлдагч оройн чандмань Очир дара хэмээн нэмэж өргөмжлөөд алтан тамга, алтан навчит өргөмжлөлийг олгуулан **Их Юань улсын хуучин ёсыг дагаж**, аливаа яамлах төрийн хэрэг шийтгэх газар хаан би ахлах боловч Жавзандамба лам чамайг шашины эзэн охь манлай хэмээн өргөмжлөх бөгөөд энгийн өдөр номын хурлын газраа ахлуулж сүслэх хэшгийг тахиж бадруулбай. Лам чи дотно нүүртэй хэшгийг хүлээсний тулд улс төр шар шашиныг өнө бат оршуулахын хутагийг барьж төр шашин дор чухал холбогдсон айлдваас зохих хэрэг тохиолдвоос алтан тамгыг дарж шууд айлдаж явахыг үүрд дагаж шийтгэгтүн.

Лам чиний төгс хувьт шавь нар ч дээд төрөлхтөн дор шүтэж зохилдох болсон орон дор оршсон өөр өөрийн сайн ерөөл эртний буян, дөрвөн их хүрдэн лүгээ төгссөн тул харьяат олон шавь нарыг дээдийн ном дор сонсох, санах, бясалгах гурвын үүднээс эши онолын эрдмийг дээрээс дээшид арвитган дэлгэрүүлэхийн явдал дор шамдан хичээлгэж, хамаг амьтаныг харшлах шалтгаан үгүй. Сансар нирваны сайн чуулган өвсөбэн бүтэх сайн үйлсийг цаг үргэлжид зохиотугай. Олноо Өргөгдсөний тавдугаар он Хаврын сүүл сарын арван нэгэн”²⁴

1915 онд Богд хааны алтан тамга, алтан навчит өргөмжлөлийг урлаж үйлдэгчдийг Богдын зарлигаар хөхүүлэн шагнасан байна.

Олноо өргөгдсөний тухайд

1911 онд Монгол улсаа тунхаглаж, Богдыг Монгол Улсын наран гэрэлт түмэн наст хаан эзэн өргөмжилсөн тухайд Жамсрангийн Цэвээн Польш гаралтай эрдэмтэн, Оросын Сангийн яам, Төв болон Дорнод Ази судлалын Хорооны төлөөлөгчөөр Монголд ажиллаж байсан Котвич (1872-1944)-д бичсэн захидалдаа: Одоо бүхий л сонин Олноо өргөгдсөний тэргүүн он хэмээн бичиж байгаа тухай дурдаад “энэ бол Энэтхэгийн Махасамди (*Mahasamdi*)-гаас үүсэлтэй юм. Наран гэрэлт (*Radiant as the Sun*) хэмээх нь хааны цол бөгөөд мөн л Энэтхэгээс уламжлалтай болох тухай тэмдэглэсэн байна.

²⁴ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, нэмж баяжуулсан хоёр дахь хэвлэл, УБ., 2011 он, 202 дахь тал

Махасамди нь Энэтхэгийн үүсгэн байгуулагч домогт хаан ажээ. Бурханы шашины нөлөөнд орсон Монголчуудын түүх бичлэгт Махасамди нь Монголчуудын өвөг хэмээн үзэж, Цагаан Сэцэний 1662 онд туурвисан Эрдэний товчид Монголын хаадын гарал үүслийг Түвд, Энэтхэгийн хаадуудын гарал үүсэлтэй холбож тайлбарласан²⁵ хэмээн эрдэмтэн Кругер бичсэн байна.

Дээр өгүүлсэн захидалдаа эрдэмтэн Цэвээн авгай 1911 оны Монголын тусгаар тогтнолыг тунхаглаж, эзэн хаанаа өргөмжлөхөд, тухайлбал Монголын тусгаар тогтнолын илэрхийлэл болсон Богд эзэн хаанд Чингис хаанаас уламжилсан зүйл байхгүй тухай тэмдэглэсэн нь үнэхээр сонин байгаа юм.

Эрдэмтэн Жамсрангийн Цэвээн авгай Монголд ирээд тун удаагүй байхдаа В.Котвичид 1912 оны 1 дүгээр сарын 22-нд захидал²⁶ бичиж, Монголын улс төр, эдийн засаг, цэрэг арми гээд л тухайн үеийн нөхцөл байдлыг нилээд тодорхой өгүүлсэн байна. Тэрхүү захидалд өгүүлэхдээ: “Одоо бүхий л цааснууд (*Монголын төрийн бичиг баримтыг хэлж буй –О.Б*) “Олноо өргөгдсөний тэргүүн он”... тэдэн сарын тэдний өдөр гэж бичиж байна. Энэ бол Энэтхэгийн Махасамади хаан, Наран гэрэлт хэмээх нь мөн л Энэтхэгийн домогт гардаг хааны нэр юм. Нэгэн зүйл миний гайхалыг төрүүлэв, юу вэ хэмээвээс Чингисийн үеийн уламжлал алга байсан явдал” хэмээн онцлон тэмдэглэжээ.²⁷

Цэвээн авгайн уулга алдан гайхшруулсан Монголын төрийн байдалыг эргэцүүлэн сайтар үзүүштэй санагдсанаа онцлон тэмдэглэж байна. Үндэсний үзэлт нэвт шингэсэн, эрдэм чадлаараа тухайн үед дээгүүрт орж байсан энэ буриад хөвгүүний нүдэнд тусаж, толгойд буусан Монголын дүр төрх хийгээд түүний дотроо хүссэн Чингисийн үеийн Монголын уламжлалын талаар маш анхааран судлууштай болохыг энд тэмдэглэж байна.

Эхлээд Цэвээн авгайн захидалдаа бичсэн зүйлсийг дэс дараалан анхааралтай үзэцгээе. Цэвээн Жамсран авгай Монголд ирэхийн өмнөхөн буюу 1910 онд Өвөр Монголын Ордост буй Эзэн хороонд очсон байжээ. Түүгээр ч үл барам энэ тухайд Цэвээн авгай Ханддоржид хэлж, Ордост буй Чингисийн Хар сүлд, түүний онгоны тухай дуулгахад Ханд ван, “тийм үү” хэмээн уулга алдан “бид таны зөвлөснөөр энэ сүлд, онгоныг Монголыг нэгтгэхэд ашиглах болно” гэж хэлж байсан ажээ. Магадгүй үүнээс улбаалж, 1913 онд Богдын засгийн газар Өвөр Монгол руу цэрэг илгээхдээ Ордост буй Чингисийн онгоныг өмгөөлөлдөө авахыг хүссэн байхыг үгүйсгэхгүй юм²⁸.

Харин Богд хаан 1911 онд Монгол Улсын хаан эзний ширээнд суухдаа өөрийн улсыг байгуулах, санаа агуулж байсан байхыг үгүйсгэж болмооргүй санагдана. Дээр өгүүлсэн Энэтхэгийн Махасамади (Makhasamdi)-гаас үүсэлтэй уламжлалыг Богд хаан бээр нилээд түлхүү ашиглахыг оролдсон нь ямар ч гэсэн бодитой ажээ. Богд хаан бээр үүнийгээ ч хэрэгжүүлэхийг зорихдоо Монгол Улсын төрийн дээд албанд лам хүмүүсийг илүүтэй үзэж, тавьж байсан болов уу. Энд би Да Лам Цэрэнчимэдийг Монгол Улсын Дотоод яамны сайдаар тавьж, улмаар энэхүү Дотоод яамны сайд нь бусдыгаа ахалж байсаныг хэлж буй юм. Мэдээжийн хэрэг Монголын тусгаар тогтнолын төлөө үндэсний хөдөлгөөнийг санаачлагч нь яах аргагүй Богд Жавзандамба хутагт мөн билээ. Түүнд

²⁵ Krueger, J.R. The Bejewelled Summary of the Origin of Khans- A History of Eastern Mongols to 1662, by Sagang Sechen (part 1), Indiana University Press: Bloomington, Ind., 1967, p.41.

²⁶ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэв, эрхэлсэн акад.Ш.Нацагдорж, УБ., 1972, 137 дахь тал

²⁷ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэв, эрхэлсэн акад.Ш.Нацагдорж, УБ., 1972, 136 дахь тал

²⁸ Uradyn E.Bulag Nationalism and Hybridity in Mongolia, Oxford University Press, 1998, p.221.

шадарлаж, үндэсний хөдөлгөөнийг тууштай дэмжигч нар бол Сайн ноён хан Намнансүрэн, Түшээ гүн Чагдаржав, Да лам Цэрэнчимэд, Чин ван Ханддорж, Хайсан гүн тэргүүтэй хүмүүс билээ. Чухамдаа 1910 аад оны үед Богдод хамгийн ойр байсан нь Сайн ноён Намнансүрэн, Түшээ гүн Чагдаржав хэмээн эх сурвалжид тэмдэглэсэн буй. Харин ноёдын нууц зөвөлгөөнөөс Оросоос тусламж эрэхээр явсан Чин ван Ханддорж тэргүүтэй Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан нарын зүтгэлийг Богд Монгол Улсын эзэн хаанаар суугаад буулгасан зарлигтаа хамгийн түрүүнд үнэлсэн хэмээн үзэх нь зөв болов уу. Улсаа тунхаглаад Монголын төрийг эмхлэн байгуулахад Богд хаанд хамгийн ойр байгаа хүмүүсийн тоонд Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан, Сайн ноён хан Намнансүрэн нарыг эх сурвалжууд ихэнхдээ нэрлэсэн буй.

Харин нь хэн нь үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийг үйл хэрэг болгоход санал санаачилга, үүрэг, рольтай байсаныг үзвээс, Богдын зүгээс илүү санаачилга гаргаж байсаныг төвөггүй харж болно. Энд би Богд өөрийн төлөөнөөс 1898, 1900 онуудад Оросын эзэнт улсын нийслэл Санкт Петербург хотруу нууцаар Бадамдорж, Цэрэн Осор нарыг илгээж, Монголын талаарх Оросын байр суурийг тандаж байсан явдал хийгээд Богд Жавзандамба хутагт Оросын Монгол дахь Консулын хоорондын найрсаг харилцаа зэргийг үндэслэн ийнхүү бичиж буй билээ.

Бүр 1895 онд Оросын Хүрээнд сууж байсан консул Я.Шишмаревын бичсэн “Очерки торговых и пограничных сношений с Монголией в период 1861–1886 гг и современное положение страны” тайланд: Монгол дахь шарын шашины тэргүүн Богд Жавзандамба хутагтыг Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийн цөм нь болж чадах хүн²⁹ хэмээн Оросууд дүгнэсэн нь тохиолдлын хэрэг бус болов уу. Нөгөө талаар Манжийн эрх баригчдын эсрэг бие даан тууштай тэмцэж ирсэн байдлыг үзвээс Богд хаанд Монголын бусад ноёдоос илүү эрх чөлөө, эрх мэдэл байсан нь илт билээ. Манжийн хаан, эрх баригчид ч монголын ноёдыг ямагт Бээжингээс уяатай байлгаж, өөрийн хараа хяналтан дор барьж байсан нь тодорхой байдаг. Үүнд Монголын ноёдод Бээжингээс жил бүр тодорхой хэмжээний пүнлүү олгож байсаныг тэмдэглэхээс гадна эл урамшууллаа багасгасанд 1910 онд ноёдууд дургүйцлээ илэрхийлсэн байдаг.

1911 онд Монгол тусгаар тогтнолоо тунхагласны дараах үеийн баримт бичгүүдэд “Их Монголын төр” гэсэн үгс тааралддаг нь Чингисийн алтан ургийн ноёд, тайж нарын нөлөөгөөр орсон эсвэл тэднийг татахын тулд Богдын хэрэглэж байсан нэр томьёо ч байж болох талтай. Үүний ч улмаас Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт: “олон аймгийн тайжийн дотор Чингис хааны хөвгүүд ач нараас үржсэнийг нь төрлийн тайж болго”³⁰ гэсэн заалт орсон байж болох талтай.

Дээрх шалтгааны улмаас Богд хаан Монголын төрийн уламжлалыг авч буй гэдгээ харуулах зорилгоор Чингис хаан ба түүний угсаа залгамжлагчдын малгайг дууриалган хааны малгайдаа “очир” хадсан³¹ хэмээн Оросын эрдэмтэн Попов бичжээ.

Богд гэгээнийг улсын эзэн хаанаар тунхаглахдаа ямар нэртэй улсын эзэн хаан болов гэдэг чухал асуудал болно. 1990 ээд оны өмнөх Монголын түүхийн бүтээлүүдэд ихэвчлэн

²⁹ Очерки торговых и пограничных сношений с Монголией в период 1861 – 1886 гг и современное положение страны. – Государственный архив Читинской области Ф.1 об, оп. 1, д.3292 л. 1

³⁰ Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг., Монгол бичгээс кирилл үсэг буулгаж, хэвлүүлсэн О.Батсайхан, З.Лонжид, УБ., 1994, 28 дахь тал

³¹ И.И.Попов От небесной империи к Серединной империи, М., 1912, с.267

Богд хаант Монгол Улс гэх буюу Автономит Монгол гэсэн нэрээр бичиж байжээ. Тухайлбал, эрдэмтэн Ш.Сандаг “Богд хаант Монгол Улс”³² гэж нэрлэж, түүхч Л.Жамсран “Олноо өргөгдсөн Монгол улс”³³ хэмээн бичжээ. Тэрбээр “Монголын төр, засгийн газрын тэргүүн нь лам нар байх болсноос хаанаа шашин төрийг хослон барьсан гэж цоллосон. Ийнхүү улс тогтсоныг бүх монголчуудын хүсэл зоригоор бий болсон гэж үзэж байсан учраас улсаа “Олноо өргөгдсөн Монгол улс” гээд хаанаа “шашин төрийг хослон баригч наран гэрэлт богд хаан” гэх болсон юм”³⁴ хэмээн бичжээ.

Түүхэн баримт үзвээс, Монгол улсын эзэн хаанд Богд Жавзандамба хутагтыг өргөмжилсний маргааш буюу 1911 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монголын Засгийн газраас Манжийн төрийн гурван яаманд явуулсан цахилгаан утсанд өгүүлэхдээ: “бүгдээр Богдыг өргөмжлөн эзэн болгож, улсын цолыг Монгол хэмээн үе уламжлан, умар зүгийн орон газрыг уул эзэн нь хураан авч бүрэн болгон батлав” гэжээ. Энэ бол архивын хөдөлшгүй баримт билээ. Энэхүү баримтыг үндэслэн нэрт түүхч, эрдэмтэн Ш.Нацагдорж “Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх” номондоо 1911 онд Монгол тусгаар тогтнолоо тунхаглаж “улсын нэрийг Монгол, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрийдэх ба Их Хүрээг Улсын нийслэл болгохоор тус тус тогтжээ”³⁵ хэмээн 1963 онд тэмдэглэж байжээ.

Улсын цол Монгол хэмээн хоёрдмол утгагүйгээр тэмдэглэжээ. Энэ бол нийт монгол овогтонд хамаатай нэр, угсаа гаралын хувьд хийгээд түүхийн хувьд нэг юм гэдгийг харуулсан үндэс болох учиртай гэж үзсэн хэрэг.

Хэдийгээр хааны цол яригдаж буй үед Олноо өргөгдсөн Монгол Улсын Наран гэрэлт түмэн наст Богд эзэн Жавзандамба хутагт хаан хэмээн нэрлэж бичдэг ч энэ нь эзэн хааны цолонд хамаатай юм.

Ар, Монгол, Гадаад монгол, Олноо өргөгдсөн Монгол, Автономит Монгол, Богд хаант Монгол гээд олон зүйлийн нэрийг өгсөн байдаг ч архивын эх сурвалжид

УЛСЫН ЦОЛ МОНГОЛ ХЭМЭЭН ТОДООС ТОД ТЭМДЭГЛЭСНЭЭС ГАДНА

УЛСЫН ТҮҮХИЙН НЭРЭНД ЗАРЛИГААР ТОГТООСОН МОНГОЛ УЛСЫН ШАСТИР \1918-1919\, хэмээн Монгол гэсэн нэрийг оруулсан байна. Эл шастирт

Манай халхын олон олон монголчуудын Чин улсын Энх амгалангийн 27 дугаар он дагаар орсноос нааш өөртөө улс болсоны Олноо өргөгдсөний тэргүүн оноос 9 дүгээр он арван нэгэн сарын шинийн есөн хүртэл аливаа дэвшсэн, буурсан зэрэг олон зүйлийг шастирт оруулан бичиж шинэтгэн зохиожээ.³⁶

ХУУЛИЙН НЭРЭНД

ЗАРЛИГААР ТОГТООСОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙЛИЙН БИЧИГ ХЭМЭЭН БИЧСЭН НЬ ЭХ ТҮҮХЭЭС УЛБААТАЙ, УЛАМЖЛАЛТАЙ БИЛЭЭ. \1913-1918

³² Ш.Сандаг Монголын улс төрийн гадаад харилцаа, Тэргүүн дэвтэр, УБ., 1971, 262,271,279 дэх тал

³³ Л.Жамсран Монголын сэргэн мандалтын эхэн, УБ., 1992, 67-68 дахь тал

³⁴ Л.Жамсран Монголын сэргэн мандалтын эхэн, УБ., 1992, 67-68 дахь тал

³⁵ Ш.Нацагдорж Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх, УБ., 1963, 268 дахь тал

³⁶ Монгол Улсын шастир, Дэд боть, УБ., 1997, 85 дахь тал

“Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичиг” 65 дэвтэрийг Монгол Улсын хаан Жавзандамбын зарлигаар төр, шашны зүтгэлтэн эрдэм мэдлэг төгс ухаант мэргэд урьд урьдын хууль цаазад тулгуурлан 1913 оны сүүлчээс 1918 оны эх хүртэлх хугацаанд боловсруулж, Улсын доод, дээд хурлаар нягтлуулж шүүлгэсний дараа зохих засвар, өөрчлөлт, нэмэлт үйлдэж, Улсын эзэн хаанаар батлуулсан байна. Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичгийг анх 65 дэвтрээр боловсруулж, нилээдийг нь хорголжин бараар хэвлэсэн ба нэг хэсэг нь гар бичмэлээрээ хадгалагдсаар эдүгээ хүрчээ. Энэхүү 65 дэвтэрийн 58 дэвтэр нь эдүгээ Монгол Улсын Үндэсний төв архив, Үндэсний төв номын санд хадгалагдаж байна. Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичиг нь дотоод, гадаадынханы сонирхлыг ихээр татаж байсан нь тухайн үеийн түүх бичлэгээс тод харагдана. Тухайлбал, Японы Мицуй Буссан пүүсийн төлөөлөгч Оошима Киёша 1917 -1920 оны хооронд Монголд хэд хэдэн удаа ирэхдээ энэхүү 65 дэвтэр Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичгийг авч, улмаар япон хэлнээ хөрвүүлэн “Хүрээнд очсон тухай илтгэлдээ” хавсаргажээ. Японы монгол хэлтэй Оошима сан тэдгээр 65 дэвтэр Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичгийг Монголоос авч, Японд ирсэн нь лав тодорхой мэдэгдэж буй билээ. Ингэхдээ ямар ч гэсэн 65 дэвтэр бүгдийг авчирсан нь мэдэгдэж байна. Энэ нь нэг талаас ямар ч гэсэн Монголчууд Хууль зүйлийн бичгийн 65 дэвтрийг бүтнээр нь зохиосон нь лавтайг нотолж буй билээ. Гэхдээ харин бүгдийг хэвлүүлж чадсан эсэхийг тодруулж чадаагүй боловч Японы пүүсийн төлөөний түшмэл Оошима уг Хууль зүйлийн бичгийн жинхэнэ гар бичмэл эхийг авчирсан гэх баталгаа үгүй билээ. Оошима бээр Монголоос авчирсан Хууль зүйлийн бичиг 65 дэвтэр бүгдийг япон хэлнээ 1922 он гэхэд хөрвүүлж чадсан байдаг. Тиймээс энэхүү япон хэл дээр буй 65 дэвтэр уг эхийг бид ямар ч байсан одоо байгаа бүрэн эх болгон одоохондоо барьж буй.

Тэрхүү хууль зохиох комисс ямар ямар хууль харааг гол болгон баримталсан тухай өгүүлэхдээ “энх цагийн олон улсын сайн хуулийг мөрдөн шийтгэж үүрд хоцроовоос зохихын тулд” урьд эрдэмтний номлосон Дайчин улсын бүгд хууль зэрэг олон хууль зүйлийн бичгийг орчуулж үзсэн хэмээжээ. Үүнд: Дайчин улсын бүгд хууль бичиг нэгэн зуун дэвтэр, Хууль зүйлийн бичиг 180 дэвтэр басхүү цэргийн яамнаас шилжүүлэн ирсэн цэргийн журганы хэргийн хууль ял хэлэлцэх хууль бүгд 69 дэвтэр, Шүүх яамнаас шилжүүлэн ирсэн Шүүх цаазны бичиг 47 дэвтэр, энэ бүгд гурван зуун жаран зургаан дэвтэр цөм манж үсгийг монголоор орчуулж нийлүүлсэн байна. 360 дэвтэр хууль болон хууль холбогдох материалыг монголчилсон гээд бодоход багагүй ажил өрнүүлсэн нь ойлгомжтой болов уу. Энэхүү Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг бол Монгол Үндэстэн тусгаар улс болон оршиж буйг илтгэн харуулсан олон зүйл заалттайн дээр өмнөх үеийн хуулиудаас дэвшилттэй болсон боловуу гэж боддог.

Монгол төрийн гал голомт- БАРУУН ӨРГӨӨ

Баруун өргөө нь Түшээт ханы дээд өвөг Абтай сайн хаан (1554-1558)-ы гэр өргөө билээ. Монгол төрийн гал голомт өргөө нь Монгол гүрний нийслэл Хархорум, Эрдэнэзуу хийдэд байгаад 1639 онд анхдугаар Богд өндөр гэгээний Өргөө өнөөгийн Нийслэлийн суурийг Ширээт цагаан нуурт тавьсны дараа гал голомт Өргөөг Эрдэнэ зуу хийдийн соёмбот суварган хэрэмнээс нүүлгэн, өндөр Богдын Өргөө шар бүсийн ордны баруун урд талд буюу их талд хүндэтгэн байрлуулснаас хойш “Баруун өргөө” хэмээх болжээ. Баруун талыг эрхэмлэх ёс нь хамгийн хүндтэй айлын гэр нь баруун урд талдаа байрладаг эртний

уламжлалтай ажээ. Баруун Өргөөг уламжлал ёсоор шашин төрийн төв орд буюу Богдын шар ордны баруун этгээдэд байрлуулдаг байжээ. Баруун Өргөөний гал голомт нь тулгын гурван чулуутай байжээ.

Баруун өргөө буюу гал голомт Өргөө нь эртний Монголын төрийн гал голомтоо хүндэлдэг ёс заншил хүндэтгэлийг залгамжлан авч, Монгол төрийн галыг бадраан, зулыг асааж бидний үед уламжлуулсан ажээ. Оросын нэрт эрдэмтэн А.М.Позднеев 1877, 1892 онд Баруун Өргөөнд хоёр удаа орж үзэж байснаа бичсэн байна.³⁷ Түүний бичсэнээр Баруун Өргөөг Автай сайн хааны өргөө гэдэг байжээ. Баруун өргөөний гадна дотно байдал, эд хэрэглэл нь номын сүм хэмээгдэх боловч лам нарын эд зүйл цөөн, гуравхан бурхантай, нэг ч лам суудаггүй, ерийн нэгэн том Монгол эсгий гэр байсан ажээ.

Энэхүү монгол гэрт Чингисийн удмын Автай сайн хаан сууж байсан хэмээн олон түмэн их хүндэлдэг байжээ. Автайн ач өндөр гэгээн Занабазар тэр Автай сайн хааны гэр өргөөг Эрдэнэзуугаас Богд Жавзандамба хутагтын өргөөний дэргэд аваачснаар Эрдэнэзууд зөвхөн буурь нь үлджээ. Баруун Өргөөг Өндөр гэгээн шашны сүмийн ёсоор шүншиглэх ёслол хийж, хурал ном хурах болж, тэр цагаас үйл ажиллагаа нь төр шашны шинжтэй Хүрээний хамт нүүж, суурьшиж байжээ.

Хүрээн дэх баруун өргөөг Автай сайн ханы сүм гэнэ. Гадна талаас нь харахад **Автай сайн ханы Монгол гэр нь таван хэлтэй өрхтэй хүнийг цочоомоор гайхам том гэр байв. Энгийн монгол гэр түүний хажууд яг л хүүхдийн тоглоом шиг харагдана. Автай сайн ханы монгол гэрт гурван зуугаад хүн уужуу багтах ажээ.** 1877 онд би дотор нь орж, тойрон явж үзэхэд бараг л хөндий мэт их зайтай асар том гэр байв. Тэнд хуран цуглуулсан эртний дурсгалт эд зүйл төдий л олон биш боловч тухайн үедээ Монголын түүхийн дурсгалт эд өлгийн зүйлийн музей шиг харагдаж байв.

Тухайлбал, хойд хананд нь байх бурханы хөргийн дэргэдэх нэг их суудал нь Манай улсын (Оросын Эзэнт гүрнийг хэлж буй) эртний их түшлэгт суудалтай их л адилхан мэт байв. Хүмүүсийн яриагаар бол тэр нь **Автай сайн ханы суудал** юм байна. Түүний хоёр хажууд нь эртний баатар эрс, Автай сайн ханы түшмэлийнх шуумал хөргийг тавьжээ. **Хөргийн өндөр нь 2 метр хагас хэртэй. Дүр догшин, харц ширүүн ажээ. Хөрөгт хуяг дуулга өмсгөж, дээд хэсгийг хүрлээр цутгаж, шижир алтаар бүржээ. Тэрхүү баатар жанжны хөргийг монголчууд бишрэн дээдэлж, Өргөө гэрт орсон хүн бүхэн түүнээс хүч чадал олохыг хүсч мөрөн дээр нь магнайгаа тулгаж, мөргөн адис авдаг гэнэ.**

Өргөө гэрийн хананд нум, сум, бамбай, сэлэм зүүжээ. Баруун Өргөөнд 20 лам тогтмол уншлага уншина. Тэд хүрээний аль ч аймагт хамаардаггүй байв.

Хамгийн их хүндэтгэл бүхий Чингис хааны удам Автай сайн ханы өвөг удам нь болох их эрх мэдэл бүхий Түшээт хааныхан Баруун Өргөөний хурал ном, ёслол хүндэтгэлийг эрхлэн гэрийн мод бүрээс хэрэгслийг шинэчлэх, засч сэлбэх, зоог шүүсний бүх зардлыг гаргадаг байжээ.

Битүүний үдэш Түшээт ханыхаас Баруун Өргөөнд ширээ засч идээ шүүс тавин будаалга хийхдээ төмөр зуух хэрэглэдэггүй эртний заншлаар гурван чулуу тулсан тулганд гал асаан ёслол хүндэтгэл үйлдэнэ. Цагаан сарын шинийн нэгний өглөө наран ургах цагт **Өргөөний гол дахь гурван чулуу тулсан тулганд Түшээт ханы алтан ургийн нэгэн тайж хатны**

³⁷ Позднеев А.М. Монголия и монголы, Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Т.1-2, СПб, типография Императорской АН, 1896 г., Позднеев А. Ургинские хутухты, Исторический очерк их прошлого и современного быта, СПб., 1879 г.

хамт ирж, хэт цахиж гал асаан “Хаан аавын цахиж асаасан, хатан ээжийн үлээж хөгжөөсөн гал голомт” гэж хэлэхэд хатан нь галаа бадрааж, хуран цугласан хаад ноёд, төрийн сайд, түшмэд золголт хийж, шинэлэх ёсны баяр эхэлдэг байжээ хэмээн Позднеев тэмдэглэсэн буй.

Баруун Өргөөний төр шашны шинжтэй нэг ёслол бол Түвдээс тодруулан залж ирдэг байсан Жавзандамба хутагтыг эхлэн Баруун Өргөөнд оруулж, төрийн ёслол үйлдүүлэн, тангараг өргүүлж, мөргүүлсний дараа ширээнд өргөмжилдөг байжээ. Тухайлбал, 1874 онд VIII Богд Агваанлуvsанчойжиннямданзанваанчигбалсамбууг Төвдөөс залж ирэхэд нь Түшээт хан Насантогтох Богдын шар ордны баруун урд талд байрлаж байсан Баруун өргөөнд хүлээн авч төрийн ёслол үйлдэж тангараг өргүүлсний дараа ширээнд нь өргөмжилж байжээ.

Гал голомт өргөөний зул хүжийг асааж, галыг нь бадраах, хурал ном хурах үүрэгтэй алтан ургийн дөрвөн тойн лам тус өргөөнд жасаалан суудаг байжээ.³⁸

Баруун өргөөний төрийн ёслол хүндэтгэл XX зууны хориод он хүртэл үргэлжилж байгаад таслагдан хаагджээ.

Баруун Өргөө нь Хуучин Богдын шар ордны баруун урд тал одоогийн Сүхбаатар дүүргийн зургаадугаар хорооны нутаг Хүүхдийн урлан бүтээх төвийн хашаан дотор баруун урд өнцөг хавьд байгаад 1930-аад оны улс төрийн хэлмэгдлийн үед устгагдан хэлмэгдэж, орон буйр нь 1950 –иад оны эцсийн хот тохижилтын ажлын үед газрын хөрснөөс арчигдсан түүхтэй³⁹ хэмээн профессор С.Ичинноров гуай бичжээ.

Жил бүрийн Цагаан сарын шинийг нэгний өглөө Түшээт ханы төлөөний хүн ирж, “хаан эцгийн цахиж асаасан гал, хатан эхийн үлээж хөгжөөсөн голомт” хэмээн хэлж хэт цахиураар гал асаадаг байсан нь Эзэн Чингисийн гал голомтыг тасралтгүй авч явааг илэрхийлсэн утгатай байв.

1911 онд Монголын тусгаар тогтнол, төр улс дахин сэргэж, Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хааны эрдэнийн суудалд залсан билээ. Үүнээс хойш Богд хаан, эх дагинын хамт жил бүрийн Цагаан сарын шинийн нэгний өглөө **Баруун өргөөнд ирж, гал асаадаг болсон байна. Энэ бол эзэн Чингисийн төрийн залгамж, уламжлалыг хадгалж буй илэрхийлсэн хэрэг юм.**

Улмаар Богдын Засгийн газрын гишүүд, сайд, түшмэд цөм Цэргийн яамны дэд сайд, бэйс Насанравжих, Гадаад яамны дэс түшмэл Сөстэй нарын санал болгож, Дотоод яамны сайд Да лам Цэрэнчимэд Богд хаантанд айлтгаснаар Нийслэл Хүрээний Баруун өргөөний Улаан сахиусны өмнө тангараг өргөсөн байна.⁴⁰

Хожим 1920 оны 1 дүгээр сард Хүрээний нууц бүлгэмийн гишүүд болох С.Данзан, М.Дугаржав, Д.Догсом, Ө.Дэндэв, Д.Сүхбаатар нар мөн л Нийслэл Хүрээний Баруун Өргөөний улаан сахиусны өмнө тангараг өргөж байжээ.

³⁸ С.Ичинноров Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар, УБ., 2009 он, 48 дахь тал

³⁹ С.Ичинноров Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар, УБ., 2009 он, 49 дэх тал

⁴⁰ Г.Дашням Монгол Улсын тусгаар тогтнол ба Нийслэл Хүрээний Баруун өргөө, Манай Монгол сэтгүүл, 2001, дугаар 01-02, х.28

Ийнхүү 1911 оны Монголын үндэсний хувьсгалы дараа монголчууд өөрийн үндэсний түүхэндээ анхаарал хандуулж, түүх, хуулиа зохиож байсаныг харж болно. Түүнээс гадна эл үеийн түүхийн эх сурвалжийн шинжтэй зохиолууд бол

Магсар хурцын Монгол Улсын шинэ түүх, \1927

1911 оны Монголын тусгаар тогтнолын асуудал нь олон үеийн эрдэмтэн судлаач нарын анхаарлыг зүй ёсоор татаж, судалгаа шинжилгээнд нь өртсөөр иржээ. Тухайлбал, Монгол орон Манжаас салж, тусгаар тогтнолоо олж авах үйл хэрэгт биеэр оролцсон Магсаржав (Олноо Магсар хурц хэмээн алдаршсан, Богд хааны номын багш) -ын 1927 онд бичсэн “Монгол улсын шинэ түүх” ном үйл хэргийг ямар нэгэн хэтрүүлэггүй бодитой дүрслэн харуулсан томоохон бүтээл болно.⁴¹

Манжич Дэндэвийн Монголын түүх \1934

Манжич Л.Дэндэвийн бичсэн «Монголын товч түүх» номонд Л.Дэндэв 1911 онд Монгол тусгаар тогтносон явдлыг «манжаас хагацаж өөрийн үндэс язгуурыг хамгаалан олон улсын дунд тусгаар чанартай улсын засгийг явуулсан гайхамшиг түүхтэй их хэргийг бүтээсэн»⁴² хэмээн дүгнэж, энэ үеийн чухал үйл явдлуудыг бүтээлдээ тод томруун тусгажээ. Магсар хурц, Л.Дэндэв нарын эдгээр бүтээл Монголын энэ үеийн түүхийн чухал сурвалж тул дараа дараачийн судлаач нарын судалгаа шинжилгээний чухал хэрэглэгдхүүн болсон юм.

Мөн бас А.Амарын Монголын түүхийг нэрлэж болох юм.

Бас нэгэн бүтээл болох - 1911 оны Монголын үндэсний хувьсгалын асуудлыг нилээд тодорхой баримттайгаар дүрсэлсэн **«Монгол улсын автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичигт»**⁴³ 1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, Богд гэгээний Улсын эзэн хаанаар өргөмжилсөн тухай өгүүлэхийн зэрэгцээ Улиастай, Ховдыг Манжийн эрх мэдэлтнүүдээс чөлөөлсөн тухай болон Өвөр Монголыг чөлөөлөх таван замын байлдаан, Бавуужавын тэмцэл зэрэг үйл явдлуудыг маш тодорхой харуулсан юм. Энэхүү баримт бичгийг Ш.Нацагдорж гуай 1960 онд хэвлэхдээ үзэл суртлын улмаас зарим зүйлсийг чухал бус хэмээн хасаж хэвлэсэн байдаг. Харин өчүүхэн судлаач О.Батсайхан миний бие хэвлэгдээгүй үлдсэн хэсгийг нөхөн оруулж, бүтнээр нь үндэсний хувьсгалын 80 жилийн ойд зориулан 1992 онд нийтлүүлсэн юм. Тэрхүү орхигдсон хэсэг дотор эзэн Чингисийн нэр байдаг юм:

Эртний цаг дор Их Юан хэмээх Монгол улсын дээд эзэн Тайчуу Богд Чингис хаан Тэмүжиний гайхамшигтай сүр буян, гавьяа эрдэм бүх бөмбөрцөг ертөнц дахин дор тугээмэл бадарч эдүгээх Ази, Европын зэрэг таван тивийн газар орон хүн

⁴¹ Н.Магсаржав Монгол улсын шинэ түүх, УБ., 1994.,99 дэх тал

⁴² Л.Дэндэв Монголын товч түүх, УБ., 1934 он, 6 дахь тал

⁴³ «Монгол улсын автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичигт» О.Батсайхан эмхтгэж хэвлүүлсэн УБ., 1992 он, 24-25 дахь тал

ардын их төлөвийг дагуулан авч ерөнхийлэн захирч явсан ба түүний дараахь арван тавдугаар үеийн хаан Тогоон Төмөрийн бие дэлхий дахины олон улсыг ерөнхийлөн захирах их төрийн эрх суурийг Мин хэмээх Хятад улсын хаан Ю Хэ Хуа Цзю Даймин Фун Лэу дор булаагдан алдаад өмнөт хятадын орноос зугатан гарч язгуурын хуучин нутаг Монгол газар дор хүрч ирээд Хэрлэн мөрний ойр Барс нэрт хотыг байгуулж харьяат Монгол олон аймгийг захиран суувай. Үүнээс хойч үе тутам дор эрдэм сүр хүчин чадал улмаар буурч улиран муудсаар эцэс дор Монгол олон аймаг удаа дараагаар салж сарнин газар газар тархаж өмнөт Хятад, Манж, хойт Оросын зэрэг гадаад улсын харьяат аймаг муж албат боол болж хуваагдан захирагдаж хоёр зуун илүү жил болбой. Энэхүү учир явдлыг бурнээ тус тус тодорхойлон тэмдэглэсэн тусгай түүх шашдир бичгууд буй тул уун дор давхарлан ул бичив. Гагцхуу одоо...

Дээр дурьдсан зүйлүүдэд Эзэн Чингисийн үеийн уламжлал бага боловч орсон болохыг харж болохоос гадна энэтхэг түвдийн уламжлал давамгайлж байсан нь тодорхой буй.

Өндөр гэгээн Занабазар Жавзандамба ламын анхан төрлийн нэр Лодойшиндонамдаг. Энэтхэгийн Дориндагийн газарт Шигмуни бурханы шавь 500 бодисадын дотроо явсан хэмээн түүх нь эхэлдэг бөгөөд Арванзургадугаар төрлийн нэр Жибузунлуvsандамбийжанцан Халхын газраа эцэг Очирбат түшээт хан Гомбодоржийн гэрт эх хатан Ханджамцаас мэндэлжээ. Өндөр гэгээн Занабазар буюу бидний нэрлэж ирснээр Анхдугаар Богд юм.

Энэ үеэс хойшхи Монголын түүх Бурханы шашинтай салшгүй холбоотой болж, Монголчуудын бичигдсэн түүх бурханы шашины нөлөөн дор орсон буй. Лувсанданзан Алтан товчийг аваад үзээд үзсэн ч мөн бусад Монголын түүхийн ном ийм маягаар бичигдсэн юм.

Монголчууд бүхэлдээ XVII-XX зууны эхэн үе болоход бурханы шашинтай болсон бөгөөд энэ тухай гадны хүний бичсэн нь XX зууны эхэн үеийн Монголыг Эзэн Чингис нь харсан бол танихааргүй шахам болтлоо өөрчлөгдөж, нөгөө омог бардам, зориг зүрхтэй, эр бярттай монголчууд номхон хүлцэнгүй болж хувирсан хэмээн тэмдэглэсэн буй.

Гэвч өвөө эмээ нар, аав ээж үүд үр хүүхэддээ Эзэн Чингисийн тухай үлгэр, домог ярьж, үндэсний омог бардам явсан гайхамшигтай түүхийн үнэн мөнийг амнаас аманд, үеэс үед өвлүүлж байсан юм. Нутаг нутгийн уул овооны тахилга, ёс заншил, уламжлал тэргүүтэн Эзэн Чингисийн үеэс улбаатай түүхийн мэдлэгийг хадгалж, өвлүүлэхэд оршиж байлаа.

Монголд өөрийн амьдралын 50 шахам жилийг өнгөрүүлсэн Оросын нэрт дипломатч Яков Шишмарев бүр 1885 онд монголчуудын талаар бичихдээ: “Монголчууд өөрийнхээ түүхийг санаж буй бөгөөд тэд тусгаар тогтнон оршихын төлөө хятадуудтай хийж ирсэн зууны тэмцлээ мартаагүй билээ. Монголчууд өөрсдийгөө дарлуулж байхыг харахад үнэхээр дургүй байгаа. Дээр нь Манжийн эрх баригчдын монголчуудыг үл ойшоосон байдал, хятад түшмэл, худалдаачдын дарангуйлал монголчуудыг тэсэх аргагүй байдалд хүргэж, тэдний хүсэл тэмүүллийг оргилуулж байна. Монголчуудын хэзээ нэгэнт цагт өөрсдийнх нь тэдэнд өгсөн хятад (дарлагдсан, ялагдсан ард түмэнд олгосон

дарлагдагч, ялагдагч хэмээх нэрийг эх сурвалжид ийнхүү тайлбарлажээ) хэмээх нэрний учирьг сайтар ухаарч буй.

Монголчуудын өнгөрсөн хийгээд ирээдүй цагийн тухай, газар сайгүй, уул хаданд хүртэл бичигдсэн төрөл бүрийн бичээсний тухай зэрэг олон домог бий⁴⁴ хэмээн тэмдэглэсэн буй.

Дүгнэлт болгох нь

1911 оны үндэсний хувьсгалын оргил үе болох Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөх, төр улс, тусгаар тогтнолоо сэргээн тунхаглах төрийн ёслолын байдлыг үзвэл чухамдаа бол Эзэн Чингисийн үеэс улбаатай Монгол төрийн уламжлал гэхээсээ илүү Энэтхэг, түвдийн нөлөө бүхий бурханы шашны уламжлал давамгайлсаныг төвөггүй харж болно. Хэзээ нэгэнц цагт омог бардам, дайнч монголчуудыг номхтгосон бурханы шашин ХХ зууны эхэн болоход монголчуудыг үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд нэгтгэх нэгэн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйл болсоныг илтгэх төдийгүй үүний илрэл нь халх монголын бурханы шашны тэргүүн Сэргээн тунхагласан Монгол Улсын төрийн тэргүүн, эзэн хаанаар өргөмжлөгдсөн явдал хэмээн үзэж байна.

Гэвч үндэс язгуур, уламжлал, газар нутаг эл бүхэн эртний монголчуудаас эхтэй нь гарцаагүй тул монгол уламжлал 1911 оны төрийн их ёслолд тодорхой эзэлж байсан гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Харин төр улс, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласаны дараа монголчууд өөрийн үндэсний түүх, уламжлалд илүү анхаарах болжээ хэмээн үзэж байна. Энд бид дээр дурьдсан Монголын түүх, уламжлалын талаар бүтээж байсан түүх, шастир, хууль зэргийг оруулж буйгаас гадна Ордост буй Чингисийн онгоны талаарх зүйлсийг ч мөн оруулсан болно.

⁴⁴ Государственный архив Читинской области Ф.1 об, оп. 1, д.3292 л. 21